

## ХОРШООГ ХӨГЖҮҮЛЭХ НИЙГМИЙН ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨР-Ш-ИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2020 оны жилийн эцсийн байдлаар

Д/д	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2020 оны зорилгот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Нэгдсэн дүгнэлт	Үнэлгээ
3.1. Хоршооны хөгжлийг дэмжсэн хууль, эрх зүйн орчныг сайжруулах зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.						
1	3.1.1. Хоршооны тухай хуулийг боловсронгуй болгож хөгжлийн өнөөгийн түвшинд нийцүүлэх;	2019 - 2024	Улсын төсвөөс 4.1 сая төгрөг		2019 оны 11-р сарын 20-ны өдрийн УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар “Хоршооны тухай” хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-аар хэлэлцэхийг дэмжсэн байна. 2020 онд хоршооны тухай хуулийг өргөн барьж ажлын хэсэг байгуулан тус хуулийг батлуулхаар ажиллаж байна. Мөн ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах дэд ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн хуралдаанд зориулж улсын төсвөөс тодорхой хэмжээний зардал гаргасан Хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зарим зүйл, заалтуудыг англи хэлнээ хөрвүүлэн олон улсын эрхзүйн зохицуулалттай нийцүүлэх зорилгоор АНУ-ын Хүнс, хөдөө аж ахуйн үндэсний төвийн зөвлөх Дэвид Седикээс зөвлөгөө авч ажилласан. Мөн хоршооллын салбарын холбоод, ХХААХҮЯ, ЖДҮГ, УИХ-ын ЭЗБХ-ны зөвлөхүүд, Бодлого судлалын төв болон бусад иргэний нийгмийн байгууллагууд оролцсон хуулийн цахим хэлэлцүүлэг зохион байгуулсан. Мөн ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан дэд ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн хуралдаанд зориулж улсын төсвөөс тодорхой зардал гаргасан.	90%
2	3.1.2. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд мал аж	2019 - 2024	-		Хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий Эдийн засгийн байнгын хорооны ажлын хэсэг, дэд ажлыг хэсгийн хуралдаануудаар Хоршооны тухай хуулийн төслийг	90%

	ахуйн бүтээгдэхүүнд ногдох нэмэгдсэн өртгийн албан татварын үйлчлэлийн ялгааг арилгах;				одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нийцүүлэн найруулж хуулийн төслийг боловсруулаад байна.	
3	3.1.3. Хоршооны онцлогийг тусгасан нэмэлт, өөрчлөлтийг хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хууль тогтоомжид оруулах;	2019 - 2024	-		Хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий Эдийн засгийн байнгын хорооны ажлын хэсэг, дэд ажлыг хэсгийн хуралдаануудаар Хоршооны тухай хуулийн төслийг одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн этгээдийн тухай хуульд нийцүүлэн найруулахаар болж хуулийн төслийг боловсруулаад байна	90%
4	3.1.4. Хөдөө аж ахуйн биржээр дамжуулан худалдан борлуулсан түүхий эдэд татварын хөнгөлөлт үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх;	2019 - 2024	-		Хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн Улсын Их Хурлын бүрэн эрх буюу 42 дугаар зүйлийн 42.1.1-д хоршооны үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн таатай орчныг бий болгох, хоршоог хөгжүүлэхэд чиглэсэн төрийн бодлогыг тодорхойлох, 43 дугаар зүйлийн 43.1.2-т түүхий эдийг бэлтгэн нийлүүлэх тогтолцоог бүрдүүлэх, 44 дүгээр зүйлийн 44.1.5-д түүхий эд, бүтээгдэхүүний нийлүүлэлт, борлуулалтын сүлжээг хөгжүүлэх гэсэн зүйл заалтуудыг нэмж найруулан батлуулахаар Хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий Эдийн засгийн байнгын хорооны ажлын хэсэг, дэд ажлыг хэсэг ажиллаж байна.	90%
5	3.1.5. Малчид, мал бүхий иргэдийн	2019 - 2024	-		Хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн Улсын Их Хурлын бүрэн эрх буюу 42 дугаар зүйлийн 42.1.1-д хоршооны үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн таатай орчныг бий болгох, хоршоог хөгжүүлэхэд чиглэсэн төрийн бодлогыг тодорхойлох, 43	90%

	<p>үндэсний үйлдвэрт нийлүүлсэн болон биржээр борлуулсан бүтээгдэхүүний урамшууллыг хоршоогоор дамжуулж олгох талаар холбогдох эрх зүйн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах;</p>			<p>дугаар зүйлийн 43.1.2-т түүхий эдийг бэлтгэн нийлүүлэх тогтолцоог бүрдүүлэх, 44 дүгээр зүйлийн 44.1.5-д түүхий эд, бүтээгдэхүүний нийлүүлэлт, борлуулалтын сүлжээг хөгжүүлэх гэсэн зүйл заалтуудыг нэмж найруулан батлуулахаар Хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий Эдийн засгийн байнгын хорооны ажлын хэсэг, дэд ажлыг хэсэг ажиллаж байна.</p>	
6	<p>3.1.6. Хоршооны салбарын эрх зүйн баримт бичигт мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар дүн шинжилгээ хийж, холбогдох санал боловсруулах;</p>	2019 - 2024		<p>Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2020 оны 02 дугаар тогтоолоор “Хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулга”-ын төсөл боловсруулах болон бусад дагалдах хуулиудыг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг УИХ-ын гишүүн С.Чинзоригор ахлуулан байгуулсан. “Хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулга”-ын төсөл боловсруулах ажлын дэд хэсгийн хурлаар Хоршооны нягтлан бодох бүртгэлийн ойлголт буруу байгааг Сангийн яамнаас тодруулж Хоршооны салбарын 100 жилийн ойтой холбогдуулан 2021 оныг “Хоршооны татвар, нягтлан бодох бүртгэлийн орчинг сайжруулах жил” болгон зарлахаар Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Б.Тэлмүүнтэй тохиролцсон. Хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зарим зүйл, заалтуудыг англи хэлнээ хөрвүүлэн олон улсын эрхзүйн зохицуулалттай нийцүүлэх зорилгоор АНУ-ын Хүнс, хөдөө аж ахуйн үндэсний төвийн зөвлөх Дэвид Седикээс зөвлөгөө авч ажилласан. Хуулийн төслийн зарим зарчмын зөрүүтэй саналыг Дэвид Седик зөвлөхийн зөвлөгөөний дагуу боловсруулан Хоршооны тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн хуралд танилцуулж дэмжигдсэн. Мөн хоршооллын салбарын холбоод, ХХААХҮЯ, ЖДҮГ, УИХ-ын ЭЗБХ-ны зөвлөхүүд, Бодлого судлалын төв болон бусад иргэний нийгмийн байгууллагууд оролцсон хуулийн цахим хэлэлцүүлэг зохион байгуулсан.</p>	90%

7	3.1.7. Хоршооны хөрөнгө өмчлөлийн онцлог байдлыг харгалзсан зээлийн журмыг хөнгөвчлөх асуудлыг шийдвэрлэх.	2019 - 2024		Хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зарим зүйл, заалтуудыг Монголын хоршоодын онцлог байдалд нийцүүлэн хоршоог өөрийн хөрөнгөтэй болгох зорилгоор хоршоог “Хоршооны хөгжлийн сан”-тай болгох, түүнийгээ захиран зарцуулах, хөрөнгө оруулах, үл хөдлөх, хөдлөх хөрөнгө худалдан авах, түүнийгээ арилжих, барьцаалах, зээлд хамрагдах гэх мэт боломжуудыг хоршоонд олгосон хуулийн төсөл боловсруулан батлуулахаар ажиллаж байна.	70%
3.2. Төр болон хоршоог дэмжигч байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлж үр дүнг сайжруулах зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.					
8	3.2.1. Хоршооны хөгжлийн талаар төр, засгийн бодлогын залгамж чанарыг тогтвортой хадгалж ажиллах;	2019 - 2024		Хоршоодын үйл ажиллагааг тогтвортой эсэхийг тогтоох, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тоо хэмжээ, хүчин чадлын талаар нарийвчилсан мэдээлэл цуглуулах, хариуцлага дотоод хяналтыг сайжруулах зорилгоор хоршоодын хөгжлийн үнэлгээ хийх ажлыг Монгол улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас аймгуудын ХХААГ-т албан тоот явуулсан. Уг ажлын хүрээнд 2020 оны 05 сарын 20-ны өдөр аймаг, сумдын Жижиг, дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхижуулах “Хоршооны хөгжлийн үнэлгээний арга зүй” сургалтыг зохион байгуулсан ба аймаг, сумын хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршоо хариуцсан мэргэжилтнүүдийг хамруулж Улсын хэмжээнд Хоршоодын үнэлгээг гаргалаа. Хоршооны салбарын хүний нөөцийг бэхжүүлэх, залгамж үеийг төлөвшүүлэх зорилгоор ЖДҮГ-аас цуврал болгон зохион байгуулж буй сургалтыг 2020 оны 12 сард Хоршоо, ахуйн үйлчилгээний салбарт баримталж буй бодлого сэдвээр 21 аймгийн ХХААГ-ын Жижиг, дунд үйлдвэр, хоршоо, ахуйн үйлчилгээ хариуцсан мэргэжилтнүүд болон ЖДҮГ-ын Фэйсбүүк пэйж, вебсайтад нээлттэй зарлал тавьж хоршоо байгуулах сонирхолтой иргэд, хоршоодын төлөөллүүдэд Хоршоо, ахуйн үйлчилгээний салбарт баримталж буй бодлого, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, салбарын хуулийн танилцуулгыг ЖДҮГ-ын Бодлого зохицуулалтын хэлтсийн хоршооны салбарын асуудал хариуцсан мэргэжилтэн В.Занданбат, Ахуйн үйлчилгээний салбарын асуудал хариуцсан мэргэжилтэн Л.Оюун-Эрдэнэ нар хийв.	90%

9	3.2.2. Ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, хүн амын хүнсний хангамжийг сайжруулах, хүнсний аюулгүй байдлыг хангах, байгаль орчны чиглэлийн төсөл, хөтөлбөрт хоршоодын оролцоог нэмэгдүүлэх;	2019 - 2024	Европын холбоо, Канадын Засгийн газар, Канадын Хоршооллын хөгжлийн сан, Чехийн хөгжлийн агентлаг, Пипл Ин нийд олон улсын байгууллагуудын санхүүжилт 89,0 сая төгрөг	АХБ-ны “Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах” төслийн хүрээнд Увс аймгийн Улаангом суманд 9 бүлгийн 77 өрх зохион байгуулалтанд орж үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээр бүлгүүд нэгдэн 3 хоршоо болж зохион байгуулагдан ажиллаж байна. Төслийн зорилтот өрхүүдэд 4x8 хэмжээтэй хүлэмж 33ш, 6x20 хэмжээтэй хүлэмж 12 ш, баруун бүсийн эрдэм шинжилгээний хүрээлэнд 6x20 хэмжээтэй хүлэмжийг тус тус хуваарийн дагуу хүлээлгэн өгөв. Хүлэмж хүлээн авсан өрхүүд хүлэмжээ 100 хувь барьж тариалалт хийж ургац хураан авлаа. - Дэлхийн байгаль хамгаалах сангаас хэрэгжүүлж буй "Ирвэстэй нутгийн ирээдүй төсөл"-өөс Баян-Өлгий аймгийн Бугат сумын "Жасыл алхаг" хоршоонд 60,0 сая төгрөгийн үнэ бүхий сүүний үйлдвэрийн тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлээ. Тус хоршоо 2019 оноос Бугат сумын төвд сүү боловсруулах үйлдвэр байгуулан амжилттай үйл ажиллагаа явуулж байна. Үйлдвэрийн нийт өртөг 166 сая төгрөг бөгөөд ЖДҮДС-гаас 40,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Тус үйлдвэрийн хүчин чадал хоногт 1-2 тонн сүү боловсруулж, тараг, цөцгий, йогурт, ааруул, шарт тос болгон савлаж, аймгийн төвийн дэлгүүрүүдээр борлуулж байна. Аймгийн төвөөс таван километр зайд оршдог Бугат суманд сүүний үйлдвэр ашиглалтад орсноор хүн амын хүнсний хангамж сайжирч, орон нутагт ажлын байр бий болох, хоршооны гишүүн малчдын орлого нэмэгдэж байна. - ХХААХҮЯ, НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллага, “Алтайн уулсын оргил” малчдын дундын хоршоо, Дундговь аймгийн ХХААГазраас хамтран 2020 оны 6 сард зохион байгуулсан “Хонины ноосны чанарыг сайжруулах” сургалтанд Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Сүхбаатар, Төв, Хөвсгөл аймгаас 40 гаруй хоршооны гишүүн хамруулсан. Уг сургалтанд НҮБ-ийн төслөөс зарим хоршоонд ноос хяргах тоног төхөөрөмж гардуулсан.ОУ-ын байгууллагуудын санхүүжилтээр МХСМТөв 7 аймгийн 20 сумын 60 гаруй хоршоодын хүн амын хүнсний хангамжийг сайжруулах дэмжих, чадавхжууоах сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулсан.	100%
10	3.2.3. Хоршоодын мэргэжлийн болон үндэсний хэмжээний нэгдсэн холбооны	2019 - 2024		Хөгжлийн шийдэл ТББ-ын хэрэгжүүлж буй BEST хөтөлбөртэй хамтран мэргэжлийн холбоодыг чадавхижуулах сургалтыг 6 сард зохион байгуулсан. Мөн цар тахлын үед ноолуурын үнэ ханш хэлбэлзэлтэй, үнэлгээ муутай, гадаад болон дотоод зах зээл хумигдсан үед хоршоодын бэлтгэсэн ноолуурыг борлуулах чиглэлээр Баянхонгор аймагт Тогтвортой ноолуур холбоогоор дамжуулан ноолуураа бэлтгэн нийлүүлэхэд 4 удаагийн зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, Гадаад болон дотоодын зах зээлд 5 хүртэлх худалдан авагчидтай холбоо тогтоон малчдын хоршоодыг холбож өгч гэрээ	70%

	чадавхыг дээшлүүлэх;			байгуулахад нь дэмжлэг үзүүллээ. Үүний үр дүнд дээрх 5 хоршоод нийтдээ 13.4 тонн түүхий ноолуур бэлтгэсэн ба борлуулалтын орлого нь 1, 652.5 сая төгрөгт хүрсэн байна. Орон нутгийн хоршоодын нийгмийн хариуцлагыг сайжруулах, хоршооны хууль эрх зүйн орчин, төрийн бодлогыг сурталчилах, хоршооны гишүүдийг чадавхижуулах, туршлага солилцох зорилгоор Дорнод, Увс, Говьсүмбэр аймагт хоршооны гишүүдийг хамруулсан сургалтыг орон нутгийн мэргэжилтнүүд хийсэн.	
11	3.2.4. Хоршоо, тэдний хөгжлийг дэмжигч байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах, цар хүрээг өргөжүүлэх, мэдээлэл солилцоог сайжруулах, салбарын мэдээллийн санг баяжуулах, хоршоо хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх;	2019 - 2024	Канадын хоршоодын хөгжил сан-25.0 сая.төг	ХХААХҮЯамнаас баталсан удирдамжийн дагуу аймгийн нийт хоршоодод хөгжлийн үнэлгээ хийх ажлыг зохион байгууллаа. Хоршоодын үйл ажиллагааг тогтвортой эсэхийг тогтоох, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тоо хэмжээ, хүчин чадлын талаар нарийвчилсан мэдээлэл цуглуулах, хариуцлага, дотоод хяналтыг сайжруулах зорилгоор хоршоодын хөгжлийн үнэлгээг бүх аймагт хийлээ. Мөн Ховд аймагт НҮБ-ийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн хүрээнд “Малын гаралтай түүхий эдийн чанар сайжруулах нь” сэдэвт уулзалт хэлэлцүүлэгт УИХ-ын гишүүн Б.Пүрэвдорж болон ХХАА-н газрын дарга Б.Бямбажав, Мал эмнэлгийн газрын дарга Д.Батцэнгэл, UNIDO төслийн төлөөлөгч Майкл Морров, НҮБ-ийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн төлөөлөгч, Арьс ширний холбоо, Махны үйлдвэрийн удирдлагууд оролцлоо. Хэлэлцүүлэг арга хэмжээний үеэр “Алтайн уулсын оргил” дундын хоршоо болон Дундговь аймгийн ХХАА-н газрын дарга Б.Мөнхжаргал, хоршоодын төлөөлөл хамтран туршлага солилцож, Ховд аймаг экспортлогч аймаг болох зорилт дэвшүүллээ. УИХ-ын гишүүн Б.Пүрэвдорж Дарви, Чандмань, Цэцэг сумдад мал угаах, хонь хяргах байгууламжийг 2021 онд байгуулахаар боллоо. Говьсүмбэр аймагт Орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор Шивээговь, Баянтал сум, Сүмбэр сумын 2020 оны 8 сарын 1-ний А/156 дугаар захирамжаар бүтээгдэхүүн үйлчилгээ явуулах, худалдаалах 5 цэг тогтоосон. Тус цэгүүдийн нээлтийн үйл ажиллагаанд зориулан сум бүр үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, үзэсгэлэн худалдаанд орон нутгийн 9 хоршоо, 55 иргэн, аж ахуйн нэгж, 20 гаруй төрлийн бүтээгдэхүүнээр оролцож, 25.4 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Мөн Төв аймагт АСК Эрдэнэ” хоршоог байгуулахад аймгийн ХХААГ-аас сургалт мэдээллээр хангаж сумынхаа ЕБС –ийн “Үдийн цай”-нд 26 нэр төрлийн хоол, 6 нэр төрлийн гурилан бүтээгдэхүүн гарган үйлчилж мөн хэрчсэн гурил үйлдвэрлэн борлуулалт хийж эхлээд байна.Хоршооллын салбарын мэдээллийн санг баяжуулах,	100%

				хоршоодын хөгжлийн өнөөгийн түвшинг тогтоох суурь үнэлгээ хийх ажлыг МХСМТ-тэй хамтран хийв.	
12	3.2.5. Хоршоо, мэргэжлийн болон үндэсний хэмжээний холбооны үйл ажиллагааг уялдуулах, хамтын ажиллагааг бэхжүүлэх;	2019 - 2024	Канадын хоршоодын хөгжлийн сан 25.0 сая.төг	Монголын хоршоологчдын үндэсний нэгдсэн холбоо, Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо, ЖДҮГ хамтран Засгын газрын 2019 оны 362 дугаар тогтоолоор батлагдсан “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр-III”-ийг орон нутагт сурталчлах, Хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал авах, амжилттай ажиллаж байгаа хоршоодын сайн туршлагыг түгээх, цаашид хамтран ажиллах боломжийг нэмэгдүүлэх, хоршооны гишүүдийн хоршооны талаарх хандлагад сэтгэл зүйн тандалт судалгаа хийх зорилгоор улсын хоршоодын “ЗӨВЛӨЛДӨХ, УУЛЗАЛДАХ” зөвлөгөөнийг 10-р сарын 29,30-ны өдрүүдэд Өвөрхангай аймгийн Арвайхээр суманд зохион байгууллаа. Тус зөвлөгөөнд мэргэжлийн хоршоодын холбооны дарга, гишүүд оролцож Хоршооны тухай хуульд санал өгч ЖДҮГ болон МХААХҮХ-оос боловсруулсан асуулга бөглөсөн. Мөн Хоршоод Брэнд бүтээгдэхүүнээ танилцуулсан үзэсгэлэн худалдаа зохион байгуулж оролцлоо. Хоршооны гишүүдийн хоршооны талаарх хандлагад сэтгэл зүйн тандалт судалгаа хийх ажил цар тахлаас болж одоогоор зогсонги байна. МХААХҮХолбооны гишүүн 493 хоршоонд засаглал, бүтээгдэхүүн үйлчилгээ, борлуулалт, хөрөнгө санхүү зэрэг олон үзүүлэлтийг багтаасан дэлгэрэнгүй судалгааг хийж гүйцэтгүүллээ. Энэхүү судалгаа ХАА-н хоршоог дэмжих стратегийг боловсруулах суурь судалгаа юм. Хоршооллын салбарын дунд хугацааны стратегийн баримт бичгийг 2019-2021 онд боловсруулж “Нэг дуу хоолой”, “Нэг дээвэр”, “Нэг имиж” гэсэн стратегийг хэрэгжүүлэх ажлыг хоршоодын мэргэжлийн, Канадын хоршооны олон улсын зөвлөх болон үндэсний холбоотой хамтран зохион байгуулж байна.	100%
13	3.2.6. Хоршоог дэмжих төрийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг	2019 - 2024		ХХААХҮЯ-ны захиалгаар сумын загвар хоршооны ТЭЗҮ, хоршооны нэгдсэн суурь судалгаа, нөхцөл байдлын шинжилгээг гүйцэтгэж ХХААХҮЯ-нд хүлээлгэн өгсөн. Азийн хөгжлийн банкны техник туслалцааны нэмүү өртөгийн сүлжээ төслийн хүрээнд Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ, Арбулаг,Цагаан-Уул,Улаан-Уул, Цэцэрлэг сумдын малчдын түүхий эдийг хоршоогоор дамжуулан бэлтгэн авч Мөрөн суманд 120тн-ийн багтаамжтай агуулахад хүлээн авч байна. Алаг-Эрдэнэ Мэлхий хадны цуурай хоршоо,Улаан-Уул Дархад малын хишиг хоршоо,Цагаан-Уул сум Энхийн амьдрал хоршоогоор дамжуулан авч байна. 2020онд нийт сарлагийн хөөвөр 10тн, ямааны ноолуур 6тн авч Жинст Мөрөн ХХК ийн складанд хадгалан Өгөөж шим ХХК-	90%

	хангах, төрийн зарим чиг үүргийг хоршоологчдын холбоогоор гүйцэтгүүлэх.			нд нийлүүлэн угаалган самнуулж бэлтгэсэн угаасан хөөвөр ноолуураа Сноу филдс ХХК ээрүүлдэг. Бэлэн болсон утсаараа Жинст Мөрөн ХХК, Мөнх бум-ууд ХХК-аар эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. 2020 онд 10 мянга орчим 800сая төгрөгний бүтээгдэхүүн үйлдвэрлэн 400сая төгрөгний бүтээгдэхүүнийг ОХУ, Герман зэрэг оронд экспортлосон. Хэнтий аймагт Тогтвортой ноос ноолуурын Эвсэл” ТББ-тай хамтран ажиллах 2020 онд стандартын тохирлын үнэлгээнд хамрагдах Өмнөдэлгэр, Жаргалтхаан, Галшар, Баянмөнх, Хэрлэн сумдын 4 хоршоо, 1 бүлгийн мэдээллийг /ТННЭ/-д авч хүргүүлээд байна. Тогтвортой ноос ноолуур эвсэл ТББ-д Хэнтий аймгаас тохирлын үнэлгээнд хамрагдах 5 хоршооны анкет, холбогдох бичиг баримтыг хүргүүлэв. Мөн ТННЭ-тэй хамтран ажиллах санамж бичигт 5 хоршоо гарын үсэг зурлаа. Засгийн газрын 32 дугаар тогтоолоор батлагдсан ХХААХҮЯам, ХАА-н биржтэй хамтран Өмнөдэлгэр, Мөрөн, Хэрлэн сумдын 991 малчин, мал бүхий иргэн 74.500 тн ноолуурыг нийт 6,332,500 төгрөгөөр "Говь Кашмер" ХХК, "Наран Золбоот" ХХК, "Үлэмж кашмер" ХХК тус тус худалдан авалт хийсэн байна. Баянхутаг, Биндэр, Хэрлэн сумдад арьс шир ноос ноолуураа малчдаас авч хоршоодоор дамжуулан зах зээлд худалдан борлуулж байна.	
3.3. Хоршоог хөрөнгө оруулалт, санхүү, зээлийн бодлогоор дэмжиж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх замаар ажлын байр нэмэгдүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.					
14	3.3.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтэд улсын төсвийн тодорхой хувийг хуваарилж байх;	2019 - 2024	Улсын төсөв 4.1 сая.төг ЖДҮХС-95.0 сая.төг ХЭДС-10.0 сая.төг Орон нутгийн төсөв-53.3 сая.төг	- /Баян-Өлгий/ Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд хоршоодын туршлага судлах арга хэмжээг зохион байгуулахад аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 2,0 сая төгрөг хуваарилсан. - /Орхон/ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хоршоодын хөгжлийн үнэлгээг орон нутгийн оролцоотойгоор хийсэн. Манай аймагт нийт 70 хоршоо бүртгэлтэйгээс 23 хоршоонд үнэлгээг хийж, үнэлгээ хийхэд шаардагдах үйл ажиллагааны зардалд улсын төсвөөс 265000 төгрөгийг хувиарласныг зориулалтын дагуу зарцуулан тайлагнасан. - /Баянхонгор/ Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 09 дүгээр сарын 14-ны өдрийн 90 тоот тогтоолоор хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр-3-ын дэд хөтөлбөрийг батлуулан ОНТөвсөөс 51.1 сая төгрөгийг батлуулж үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. - /Дорнод/Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд 27,0 сая төгрөгийг тусган ажиллаж байна. - /Говьсүмэр/ 2020 онд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлдэг 1 хоршоо хөнгөлөлттэй зээлд хамрагдаж 95.000.000 сая	70%



				төгрөгийн дэмжлэг олгосон. ХЭДС-н хөдөө аж ахуйн чиглэлээр 1 хоршоонд 10.0 сая төгрөг олгосон байна.2019 оны 11-р сарын 20-ны өдрийн УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар “Хоршооны тухай” хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-аар хэлэлцэхийг дэмжсэн байна. 2020 онд хоршооны тухай хуулийг өргөн барьж УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны ажлын хэсэг байгуулсан Мөн ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан дэд ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн хуралдаанд зориулж улсын төсвөөс тодорхой хэмжээний зардал гаргасан.	
15	3.3.2. Хоршооны бүтээгдэхүүн борлуулалтын төв, хөдөө аж ахуйн болон жижиг, дунд үйлдвэрийн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангамжийн дундын цэгийг орон нутагт байгуулж, хоршоодын захиалгын дагуу нийлүүлэх тогтолцоог бүрдүүлэх;	2019 - 2024		Хоршооны бүтээгдэхүүн борлуулалтын төв, хөдөө аж ахуйн болон жижиг, дунд үйлдвэрийн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангамжийн дундын цэгийг орон нутагт байгуулж, хоршоодын захиалгын дагуу нийлүүлэх тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Өмнөговь аймхг Хөдөө аж ахуйн техник дундын үйлчилгээний төвийн ТЭЗҮ, зураг төсвийн дагуу "ЭС АЙ СИ ЭЙ" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж, зураг төсвийн дагуу тус төвийн гадна шугам сүлжээ, оффис, агуулахын барилга байгууламж, шаардлагатай тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолтыг боловсруулан хоёр багц болгож, төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг зохион байгуулсан. Хөдөө аж ахуйн дундын техник үйлчилгээний төвийн явуулын барилга, тоног төхөөрөмжийг Улсын төсвийн 1098248170 /нэг тэрбум ерэн найман сая хоёр зуун дөчин найман мянга нэг зуун дал/-н төгрөгөөр худалдан авах ажлыг хийж, Булган суманд тус төвийн байгуулах ажлыг зохион байгуулж байна. дүн бүхий гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна. Мөн Тав аймагт ХХААХҮЯамны сайдын А/177 дугаар тушаалаар 50 морины хүчин чадалтай хүнсний ногооны иж бүрдэл 2 ширхэг тракторыг олгосон. Тус тоног төхөөрөмжийг хоршоод хүнсний ногооны тарилалт, ургац хураалтандаа техник дунд үйлчилгээгээр ашиглаж байна. Ховд аймагт Хоршооны бүтээгдэхүүн борлуулах төвийг Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын дэргэд “Ховдод үйлдвэрлэв” төв, Их буян зах, Эвийн хүч хоршооны үйлчилгээний төв, Булган, Зэрэг сумдад ажиллуулж байна.	90%
16	3.3.3. Ажлын байр нэмэгдүүлэх болон хөдөлмөр эрхлэлтийг	2019 - 2024	ЖДҮХС-460.76сая.төг СХС-268.0 сая.төг Гадаадын	2020 онд 460,760,000 төгрөгийг ажлын байр нэмэгдүүлэх, үйл ажиллагаагаа өргөтгөх зорилгоор 7 Хоршоо ЖДҮХС-аас зээл авсан байна. Жишээ дурдвал Өмнөговь аймгаас Номгон сумын “Бат-Амгалан хөрх” хоршоо 74.0 сая төгрөгний хөнгөлөлттэй зээл авсан байна. Мөн орон нутгийн сум хөгжүүлэх сангаас Цогтцэций сумын “Сүргийн хөгжил” хоршоонд 18.0 сая төгрөгийн зээл, нийт 92.0 сая төгрөгний зээл олгосон	100%

	дэмжих санхүүжилтийн тодорхой хэсгийг хоршооны салбарын үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжихэд зарцуулах;		төсөл-11.0 сая.төг		байна. Нийт 9 хүнийг ажлын байраар хангасан. Баянхонгор аймагт Сум хөгжүүлэх сангаас 2020 онд 116 төсөлд 807.0 сая төгрөгийн зээл олгосноос хоршооны 22 төсөлд 250.0 сая төгрөгийн зээлийг олгосон байна. Мөн Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, Хөдөөгийн хөгжил төслөөс малчдын өрхийн үйлдвэрлэлийг дэмжих эрүүл аюулгүй хүнс үйлдвэрлэх боломж нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Өлзийт сумын Наянбулаг тал хоршоонд 11 сая төгрөгийн өртөг бүхий 10 нэр төрлийн сүү сүүн бүтээгдэхүүн боловсруулах иж бүрдэл тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй олгосон. Эдгээр тоног төхөөрөмжийг олгосноор тус хоршоо нь 17 тн сүү боловсруулан 37.8 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Мөн Файл хавсаргав.	
17	3.3.4. Загвар хоршоог байгуулж, хөрөнгө санхүүгээр дэмжих;	2019 - 2024			Говь-Алтай аймагт Улсын тэргүүний Буян-Ундрал, Хужирт жавхлан, Алтан тэвш хоршоод үйл ажиллагаа явуулж байна. Дээрх хоршоод нь 2020 онд нийт 71.7 сая төгрөгийн ногдол ашгийг гишүүдэд хуваарилсан байна. Мөн малчдын байгуулсан анхан шатны хоршоодын үйл ажиллагааг дэмжин шинэ Загвар хоршоо байгуулах зорилгоор Баян-Уул сумын Санжинбогд хоршоог дэмжин ажиллаж байна. Тус хоршоог түшиглэн мал нядалгааны цех, мах боловсруулах жижиг үйлдвэр байгуулахаар судалгааны ажлыг хийж, Ирвэстэй нутгийн ирээдүй төслийн санхүүжилтээр ТЭЗҮ, барилгын зураг төсөв, бизнес төлөвлөгөөг боловсруулан өгөөд байна. Дархан-Уул аймгийн Хонгор сум Зэдрийн булаг хоршоо 15 малчдын малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг тээвэрлэх, борлуулах, малчдад шаардлагатай бүтээгдэхүүнийг зах зээлээс нийлүүлэх ажлыг хамтын хүч оролцоо дээр тулгуурлан ажиллаж, орон нутгийн Загвар хоршоо болохоор холбогдох байгууллагуудаас сургалт мэдээлэл авч ажиллаж байна. Мөн Сэлэнгэ аймгийн ХХААГ Хүнс, хөдөө аж ахуйн газар нь “Сэлэнгэ таван хайрхан” дундын хоршоотой хамтран, хоршоодын үйл ажиллагааг идэвхжүүлэх, чадавхижуулах чиглэлийн үйл ажиллагааг тогтмол явуулж байна. Энэ дундын хоршоонд 3 сумын 12 анхан шатны хоршоог гишүүнчлэлээр бүртгүүлсэн бөгөөд "Загвар хоршоо" болох зорилт тавин ажиллаж байна.	50%
18	3.3.5. Орон нутгийн өмчлөлд байгаа ашиглагдахгүй барилга	2019 - 2024			Орон нутгийн өмчлөлд байгаа ашиглагдахгүй барилга байгууламжийг хоршоонд түрээслүүлэх, эзэмшүүлэхэд Өмнөговь аймгийн Даланзадгад сумын газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг “Диваажингийн зам” хоршоонд хуучин татварын хэлтсийн байрыг түр хугацаагаар түрээсийн хөнгөлөлттэй нөхцөлөөр ашиглуулж байгаа бөгөөд цаашид уг барилгыг аймгийн ЗДТГ-т хүсэлт	90%

байгууламжийг хоршоонд түрээслүүлэх, эзэмшүүлэхэд дэмжлэг үзүүлэх.				гарган хоршоологчдод эзэмшүүлэх, ашиглуулах ажлыг зохион байгуулж байна. Мөн Баянхонгор аймгийн Баянлиг, Жинст, Баянбулаг, Галуут,, Баянхонгор, Гурванбулаг сумдад 8 барилга байгууламжийг хоршоонд түрээслүүлэх болон эзэмшүүлж байна. Баян-Өлгий аймгийн Буянт сумын Жолжахсы хоршоо болон Бөртөөш хоршоод сумын хуучин эмнэлгийн байрыг эзэмшин үйл ажиллагаа явуулж байна. Мөн Алтай сумын Жана ауыл хоршооны эсгийний үйлдвэр хуучин моторын барилгад үйл ажиллагаагаа явуулж байна. Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын Засаг даргын тамгын газрын мэдэлд байсан соёлын төвийн барилгыг Тунгалаг-Уст-Шураг хоршоонд эзэмшүүлсэн. Орхон аймгийн Жаргалант суманд байрлалтай орон нутгийн өмчлөлд байсан ашиглагдахгүй барилгыг “Шонхорын хүч” ногоочдын хоршоонд 2020-2025 онд эзэмшүүлэх гэрээг хийж, ногоочдын хоршоог дэмжин ажилласан. Увс аймгийн Ховд сум “Цаст сүрлэг гурван хороо” хоршоонд ашиглагдахгүй байгаа ЗДТГ-ын барилгыг оффис дэлгүүрийн зориулалтаар эзэмшүүлж үйл ажиллагааг нь дэмжин ажиллаж байна. Хэнтий аймгийн Хэрлэн сумын "99 хоршоо" орон нутгийн өмчийн ашиглагдахгүй байсан хуучин барилгыг түрээсийн төлбөргүй ашиглан хүнсний ногоо боловсруулах чиглэлээр ажиллаж байна.	
3.4. Хоршоогоор дамжуулан түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлт, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээний оновчтой тогтолцоог бий болгох замаар орон нутгийн хөгжлийг дэмжих зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.					
3.4.1. Түүхий эд, бүтээгдэхүүний нийлүүлэлт, 19 борлуулалтын сүлжээг хөгжүүлэх;	2019 - 2024			МХААХҮХ, Лавай худалдааны төвтэй хамтран 2020 онд Хөдөө аж ахуйн хоршоодын бүтээгдэхүүний Задгай талбайн худалдаа зохион байгуулж ажиллав. Мөн ХХААХҮЯ-аас жил бүр уламжлал болгон зохиун байгуулдаг “Намрын ногоон өдрүүд -2020” үзэсгэлэн худалдаанд хөдөө аж ахуйн хоршоологчдын бүтээгдэхүүнийг АГРИ-КООП нэрийн дор оролцуулав. Төв аймгийн Эрдэнэ суманд зохион байгуулагдсан хоршоологчдын зөвлөгөөний үеэр 16 аймаг, нийслэлийн хоршоологчдын бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг зохион байгуулж ажиллав.	70%
20 3.4.2. Нийслэл, бүсийн төвд түүхий эд, бараа, бүтээгдэхүүний арилжаа, тээвэр ложистикийн төв байгуулж	2019 - 2024			Хоршоодын техник, тоног төхөөрөмжийг шинэчилэх ажлын хүрээнд шаардлага хангасан ҮХ-ны гишүүн 4 хоршоонд ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг ЖДҮГ-аас арьс боловсруулах тоног төхөөрөмжийг хөнгөлөлттэй нөхцөлөөр олгосон. МХААХҮХ, Лавай худалдааны төвтэй хамтран 2020 онд Хөдөө аж ахуйн хоршоодын бүтээгдэхүүний Задгай талбайн худалдаа зохион байгуулж ажиллав. Мөн ХХААХҮЯ-аас жил бүр уламжлал болгон зохиун байгуулдаг “Намрын ногоон өдрүүд -2020”	70%

	хоршоодын оролцоог нэмэгдүүлэх, техник, тоног төхөөрөмжийг шинэчлэхэд дэмжлэг үзүүлэх;			үзэсгэлэн худалдаанд хөдөө аж ахуйн хоршоологчдын бүтээгдэхүүнийг АГРИ-КООП нэрийн дор оролцуулав.	
21	3.4.3. Үндэсний үйлдвэрт хоршоо бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэх, харилцан ашигтай хамтран ажиллах тогтолцоог хөгжүүлэх;	2019 - 2024		Увс аймагт ЗБДСангийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан нэг аж ахуйн жилд 1000 тн ноос угаах хүчин чадалтай үйлдвэрийг ашиглалтанд оруулсан, мөн Тариалан суманд ноос боловсруулах үйлдвэр ашиглалтанд орсон нь сумдын жижиг үйлдвэр, цехүүд угаасан ноосоо орон нутгаасаа нийлүүлэх боломжийг бий болголоо. Баянхонгор аймгийн “Бүлээн ус эрдэнэ”, “Баянгичгэнэ” зэрэг хоршоод нь Үндэсний үйлдвэрт ноос бэлтгэж, Тогтвортой ноолуур эвсэлд 2 хоршоо, тогтвортой ноолуур холбоонд 4 хоршоо нийт 10 хоршоо ноос, ноолуур бэлтгэн үндэсний үйлдвэрт нийлүүлсэн байгаа. Цаашид харилцан ашигтай хамтран ажиллах тогтолцоог хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулан үйлдвэрүүдтэй хэлэлцээр хийн ажиллаж байна. НҮБ-ын UNIDO байгууллагатай хамтран арьс ширэн түүхий эдийг зах зээлийн эргэлтэд оруулах судалгааны ажил хийгдэж байна.	70%
22	3.4.4. Хоршоодын бэлтгэсэн малын гаралтай түүхий эдийг хөдөө аж ахуйн биржээр арилжих ажлыг эрчимжүүлэх;	2019 - 2024		Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооны гишүүн 57 хоршоог ХАА-н биржийн итгэмжлэгдсэн хоршоогоор сонгож биржийн арилжаанд оролцуулах зорилгоор ХХААХҮЯ, Хөдөө аж ахуйн биржтэй уулзалт хийж боломжуудыг эрэлхийлж ажиллаж байна.	50%
23	3.4.5. Түүхий эд бэлтгэх, чанарын хамгаалалт, тордолт хийх төвийг хоршооны	2019 - 2024		Сүхбаатар аймгийн Баруун-Урт суманд Түмэн цагаан ноос хоршоо, Дөрвөн гэгээн эрдэнэ хоршоо, Өндөр хамар хоршоод түүхий эд бэлтгэх үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Мөнххаан, Баяндэлгэр, Түвшинширээ сумдаад түүхий эд бэлтгэх, чанарын хамгаалалт, тордолт хийх төвийг хоршооны бүтцэд тулгуурлан байгуулсан. Мөн Баянхонгор аймгийн Жинст сумын "Түйн хишиг", Богд сумын "Орог нуурын хишиг", Шинэжинст сумын "Цармын цагаан сувд", Баацагаан сумын "Цанхир хайрхан",	70%

	бүтцэд тулгуурлан сумдад байгуулах.				Бөмбөгөр сумын "Өгөөж баян-Өлзийт гол" зэрэг хоршоодын бүтцэд тулгуурлан түүхий эд бэлтгэх чанарын хамгаалалт, тордолт хийх төвийг байгуулсан.	
3.5. Хоршооны “Сайн засаглал”-ыг төлөвшүүлэн нийгмийн үнэлэмжийг дээшлүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.						
24	3.5.1. Хоршооны нийгэмд эзлэх байр суурь, үнэлэмжийг дээшлүүлэх;	2019 - 2024			Ковидын цар тахлын үед хүнс үйлдвэрлэгчид болох хоршоологчдын гүйцэтгэж буй үүргийг олон нийтэд таниулах үүднээс FOOD HERO гэсэн лого бүхий амны хаалтыг эмэгтэйчүүд давамгайлсан хоршоогоор хийлгүүлэн төр, засгийн байгууллагууд, нутгийн удирдлагын байгууллагууд болон олон улсын байгууллагууд, төсөл хөтөлбөрүүдээр тарааж хоршоологчдыг дэмжин ажиллахыг уриалав. Мөн Цар тахлын эсрэг залуу хоршоологчдын дуу хоолойг хүргэх үүднээс ҮХ-ны дэргэдэх Залуучуудын хороо болон хоршоодын залуу гишүүд олон улсын бүжгийн тэмцээнд олон нийтийн цахим сүлжээгээр дамжуулан оролцуулсан. Олон нийтийн сүлжээний хандалтаараа олон улсад 2-р байрт орсон амжилт гаргасан байна. Хоршооны тухай ойлголтыг нийгэмд түгээх зорилгоор МХААХҮХ, МҮҮХХ ЗЗБУХ төсөлтэй хамтран 5 сэдвээр видео хичээл болон тэргүүний хоршоодын туршлагыг баримтжуулан түгээлээ	90%
25	3.5.2. Хоршооны талаарх олон нийтийн хандлагад сэтгэл зүйн тандалт судалгаа хийж холбогдох арга хэмжээг авах;	2019 - 2024			Монголын хоршоологчдын үндэсний нэгдсэн холбоо, Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо, ЖДҮГ хамтран Засгын газрын 2019 оны 362 дугаар тогтоолоор батлагдсан “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр-III”-ийг орон нутагт сурталчлах, Хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал авах, амжилттай ажиллаж байгаа хоршоодын сайн туршлагыг түгээх, цаашид хамтран ажиллах боломжийг нэмэгдүүлэх, хоршооны гишүүдийн хоршооны талаарх хандлагад сэтгэл зүйн тандалт судалгаа хийх зорилгоор улсын хоршоодын “ЗӨВЛӨЛДӨХ, УУЛЗАЛДАХ” зөвлөгөөнийг 10-р сарын 29,30-ны өдрүүдэд Өвөрхангай аймгийн Арвайхээр суманд зохион байгууллаа. Тус зөвлөгөөнд мэргэжлийн хоршоодын холбооны дарга, гишүүд оролцож Хоршооны тухай хуульд санал өгч ЖДҮГ болон МХААХҮХ-оос боловсруулсан асуулга бөглөсөн. Мөн Хоршоод Брэнд бүтээгдэхүүнээ танилцуулсан үзэсгэлэн худалдаа зохион байгуулж оролцлоо. Хоршооны гишүүдийн хоршооны талаарх хандлагад сэтгэл зүйн тандалт судалгаа хийх ажил цар тахлаас болж одоогоор зогсонги байна.	70%

26	3.5.3. Төрийн худалдан авалтад өөрийн бүтээгдэхүүнийг нийлүүлэхэд хоршоод идэвх санаачилгатай оролцох;	2019 - 2024		Өмнөговь аймгийн хэмжээнд идэвхитэй үйл ажиллагаагаа явуулж байгаа хоршоодыг чадавхижуулах, олон улсын болон дотоодын төсөл хөтөлбөрүүдэд хамруулах, дотоодын худалдан авалтад бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт хийхэд бэлтгэх зорилгоор Өмнөговь аймаг дахь “Бизнесийн инноваци хөгжлийн төв”-д хүсэлт гарган төслийн менежмент, бизнес төлөвлөгөө, тендерийн бичиг баримт бэлдэх сургалтанд 8 сумын 14 хоршооны 16 хоршоологчдыг 576.0 маянган төгрөгний төлбөртэй сургалтанд орон нутгаас 280.0 маянган төгрөгний сургалтын шимтгэл төлөн төлбөрийг 100% чөлөөлж хамруулаад байна. Баян-Өлгий аймаг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан эдийн засгийн хүндрэлийг даван туулах онцгой бодлого, "Үндэсний үйлдвэрлэл", “Төрийн өмчийн худалдан ашиглалт, хяналтыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх” зорилтын хүрээнд хоршоод сургуулийн үдийн цай хөтөлбөрт бүтээгдэхүүн нийлүүлж байна. Аймгийн хэмжээнд дотоодын үйлдвэрээс 2138,5 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, барилгын материал, сургууль цэцэрлэгийн хоол, хүнс, үдийн цай зэрэг бүтээгдэхүүнийг худалдан авсан байна.	70%
27	3.5.4. Хоршооны салбарын хүний нөөцийг бэхжүүлэх, залгамж үеийг төлөвшүүлэх;	2019 - 2024	Канадын хоршоодын хөгжлийн сан -10 сая.төг	Хоршооны салбарын хүний нөөцийг бэхжүүлэх, залгамж үеийг төлөвшүүлэх зорилгоор ЖДҮГ-аас цуврал болгон зохион байгуулж буй сургалтыг 2020 оны 12 сард Хоршоо, ахуйн үйлчилгээний салбарт баримталж буй бодлого сэдвээр 21 аймгийн ХХААГ-ын Жижиг, дунд үйлдвэр, хоршоо, ахуйн үйлчилгээ хариуцсан мэргэжилтнүүд болон ЖДҮГ-ын Фэйсбүүк пэйж, вебсайтад нээлттэй зарлал тавьж хоршоо байгуулах сонирхолтой иргэд, хоршоодын төлөөллүүдэд Хоршоо, ахуйн үйлчилгээний салбарт баримталж буй бодлого, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, салбарын хуулийн танилцуулга хийлээ. “Залуу хоршоологчдын бүсийн зөвлөгөөн”-ийг Баруун бүс Завхан аймагт, Зүүн бүс Сүхбаатар аймагт, Төвийн бүс Улаанбаатар хотод, мөн Архангай, Өвөрхангай аймагт тус тус зохион байгуулж 300 гаруй залуу хоршоологчдыг чадавхжуулах, залгамж үеийг төлөвшүүлэх, хоршооны дотоод хяналтыг сайжруулах сургалт мэдээллийн ажлыг хийв.	90%
28	3.5.5. Хоршооны гишүүдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх,	2019 - 2024	Канадын хоршоодын хөгжлийн сан-10 сая.төг	Хоршооны салбарын хүний нөөцийг бэхжүүлэх, залгамж үеийг төлөвшүүлэх зорилгоор ЖДҮГ-аас цуврал болгон зохион байгуулж буй сургалтыг 2020 оны 12 сард Хоршоо, ахуйн үйлчилгээний салбарт баримталж буй бодлого сэдвээр 21 аймгийн ХХААГ-ын Жижиг, дунд үйлдвэр, хоршоо, ахуйн үйлчилгээ хариуцсан мэргэжилтнүүд болон ЖДҮГ-ын Фэйсбүүк пэйж, вебсайтад нээлттэй зарлал тавьж	90%

	дотоод хяналтыг сайжруулах;			хоршоо байгуулах сонирхолтой иргэд, хоршоодын төлөөллүүдэд Хоршоо, ахуйн үйлчилгээний салбарт баримталж буй бодлого, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, салбарын хуулийн танилцуулга хийв. “Залуу хоршоологчдын бүсийн зөвлөгөөн”-ийг Баруун бүс Завхан аймагт, Зүүн бүс Сүхбаатар аймагт, Төвийн бүс Улаанбаатар хотод, мөн Архангай, Өвөрхангай аймагт тус тус зохион байгуулж 300 гаруй залуу хоршоологчдыг чадавхжуулах, залгамж үеийг төлөвшүүлэх, хоршооны дотоод хяналтыг сайжруулах сургалт мэдээллийн ажлыг хийв.	
29	3.5.6. Хоршооны засаглалд хүйсийн тэгш байдлыг хангах.	2019 - 2024	Канадын хоршоодын хөгжлийн сан-26.0 сая.төг	Хөдөө аж ахуйн салбарын эмэгтэйчүүдийн оролцоо, үнэлэмжийг нийгэмд таниулах, тэдний манлайллыг хөгжүүлэх зорилгоор Увс аймагт Хоршоологч эмэгтэйчүүдийн хороог байгуулаа. Энэхүү санал санаачилгыг гаргасан МХААХҮХ-той хамтран цаашид 21 аймагт өрнүүлэх зорилготой ажиллаж байна. Монголын хоршооллын сургалт мэдээллийн төвтэй хамтран “Хоршооны жендэрийн бодлого” гарын авлага боловсруулан гаргаж хоршоодод түгээх, 5 аймгийн 10 сумын 25 хоршооны удирдлага гишүүдэд жендэрийн тухай ойлголт олгох сургалтыг зохион байгуулав. 15 сая канад хоршоодын хөгжлийн сан Хадгаламж, зээлийн хоршоодын “Эмэгтэй удирдагчид” сургалтыг Канадын хоршооны олон улсын зөвлөхийг 7 хоногын хугацаатай урьж хадгаламж зээлийн хоршоодын удирдлагын түвшинд ажиллаж буй эмэгтэйчүүдэд сургалт оров.	90%

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**